



Жендэрт суурилсан хүчирхийлэл, ба
түүнийг таних нь



Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ

Дэлхийг 1000 хүнтэй тосгон гэж бодъё

- Бидний 500 нь эмэгтэй, яг үнэндээ 510 байх ёстой ч 10 нь эмэгтэй хүйсээсээ болж хорвоод мэндэлж чаддаггүй.
- Эндээс 300 нь Ази эмэгтэй.
- 167 эмэгтэй амьдралынхаа туршид ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж эсвэл зодуулдаг.
- Түүнчлэн 100 эмэгтэй нь хүчингийн гэмт хэргийн золиос, эсвэл хүчиндэхээр завдсан халдлагын золиос болдог.

Жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл:
Хүчиндэх (хүүхдийн эсрэг, ураг төрлийн, гэрлэгсдийн, болзооны, үзэн ядалтын, дайны, “сургаж” гэх мэт)
- Хүчээр жирэмслүүлэх
- Уламжлалт хүчирхийлэл
(удам судар, нэр хүндээ хамгаалж егүүтгэх, гадаад төрхийг зэрэмдэглэх, эм бэлэг эрхтнийг зэрэмдэглэх гэх мэт)
- Хүний наймаа, бэлгийн мөлжлөг
- Хүчээр гэрлүүлэх
- Ажлын байран дах бэлгийн дарамт
- Сэтгэл санааны дарамт, доромж
- Хүйснээс хамаарч үр хөндөх
- Гадаа, гудамжинд дарамтлах...

БЭЛГИЙН ДАРАМТ ГЭЖ ЮУ ВЭ?

Бэлгийн дарамт гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр болон өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсвэл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас сурч боловсрох, ажил эрхлэх, албан тушаал хаших эрхэд халдсан, нэр төр, алдар хүндийг гутаасан, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхгүйг хэлэх бөгөөд өөр болон ижил хүйсийн хүмүүсийн хооронд үүсч болно.

Бэлгийн дарамт нь дараах хэлбэрээр илэрдэг ба үүгээр хязгаарлагдахгүй:

зохисгүйгээр ширтэх, гөлрөх;	бэлгийн сэдэвтэй зүйрлэл, онигоо ярих;	санаандгүй мэтээр шүргэх, ёврох, зөвшөөрөлгүйгээр хүрэх, тэврэх, үнсэх, хоргоох;
хувь хүний биеийн хэлбэр, согогийн талаар ярих;	бэлгийн чадавх, зан үйл, туршлагын тухай ярих;	хэн нэгний бэлгийн амьдрал, хүйсийн илэрхийлэл, бэлгийн чиг баримжааны талаар хов жив ярих, цуурхал тараах;
бэлгийн сэдэл бүхий дохио зангаа, байрлал үзүүлэх, биеийн зохисгүй хэсгээ харуулах;	хувийн болон бэлгийн сэдлээр утсаар ярих, захидал, мессеж илгээх;	бэлгийн дур сонирхлоо далдуур илэрхийлсэн зүйлс, зураг, порнограф үзүүлэх, дуу авиа сонсгох;
хүчиндэх, хүчиндэхээр завдах;	шалтгаангүйгээр, шаардлагагүй тохиолдолд уулзах, болзох санал тавих, бэлэг өгөх, мөрдөж мөшгих;	хурьцал үйлдэх болон бусад бэлгийн үйлдэл хийхээр санал тавих, шалах, дарамтлах;

Хэрвээ та бэлгийн дарамтын хохирогч эсвэл гэрч болсон бол дээд шатны удирдлагадаа болон ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС-т хандаарай!

Гомдол, мэдээлэл хүлээн авах утас: 7000-0222

Цахим шуудан: info@mn-nhrc.org

Хаяг: Засгийн газрын 11 дүгээр байрны 509 тоот өрөө



ХЭҮК



Young
Women
for Change

АЖЛЫН БАЙРАНД...

Ажлын байрны бэлгийн дарамт (АББД) *Монголд*



Таван эмэгтэй хүний нэг нь АББД-д өртсөн байна. (2018)



АББД-ын арван хохирогч тутмын ес нь эмэгтэй хүн байна. (2016)



Хохирогчдын 1/3 нь үг хэлээр, 1/5 нь үйлдлээр, 1/3 нь бие махбодын дарамтад өртжээ. (2016)

Дээрх тоо баримтыг АББД-тай холбоотой судалгаанууд болон ХЭҮК-ын жил бүрийн УИХ-д өргөн барьдаг илтгэлээс оруулсан болно.



Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуульд АББД их илэрч байсан бол сүүлийн жилүүдэд эрүүл мэнд, бизнес, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг салбарт АББД үйлдэгдэх нь нэмэгдсэн байна. (2004, 2017)

Мөн төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, хувийн хэвшил, албан бус хөдөлмөрийн салбарт АББД илрэх нь нэмэгдэж байна. (2012-2017)



Хохирогчдыг улам ноцтой, жигшм хэлбэрээр дарамталж, хохирогчийг гэр бүлээс нь салгасан, хүчиндсэн, жирэмсэн болгосон байна. (2016)

Ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээ, хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоо хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээхэд хангалтгүй хэвээр байсаар байна.

**Хүчирхийлэлд өртсөн эсэхийг ахлах
ажилтан удирдлагууд таних мэдэх ямар
боломж байдаг бэ?**

- Ажлын байран дээр таних/мэдэх илүү боломжтой хүчирхийллийн хэлбэрүүд:
 - Гэр бүлийн хүчирхийлэл
 - Ажлын байрны бэлгийн дарамт
 - Ялгаварлан гадуурхалт (ЛГБТ, цөөн хүйс, “стандарт”-аас өөр хүн)

- Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн ихэнх (71.6 хувь) нь хүнд буюу ноцтой бэртэж, таван эмэгтэй тутмын хоёр (21.0 хувь) нь хөнгөн гэмтэж, 5.0 хувь нь дунд зэрэг гэмтжээ. Гэмтэж, эмнэлгийн тусламж авсан эмэгтэйчүүдийн **тал хүрэхгүй хувь (43.2 хувь)** нь гэмтлийн бодит шалтгаанаа эмнэлгийн ажилтанд мэдээлсэн байна.

Хүчирхийллийн нүцгэн
үнэн судалгаа, 2017

- Ажилтнуудын 43.6 % гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан, үүний 33.6 % нь сүүлийн нэг жилд.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ажилтны 5-27% нь ажлаа алддаг.

**ONTARIO FEDERATION OF LABOUR,
West Ontario, Canada, 2016**

- 461 оролцогчтой судалгаанд оролцогчтой 6.1 хувь нь АББД-д өртсөн гэсэн ба үүний **56.8 хувь** нь нууцалж өнгөрөөсөн, 22.5 хувь нь удирдлагуудад хэлсэн ба үүний 18.2 хувь нь удирдлагууд арга хэмжээ авсан гэж хариулсан.

Нийслэлийн жендэрийн нөхцөл
байдлын судалгаа, 2018

3. Илэрсэн нөхцөл, нотлох баримтад үндэслэн дараах арга хэмжээнүүдийн аль тохирохыг авдаг.

- Таныг ажлын байрны бэлгийн дарамтанд өртсөнийг тогтоовол тухайн үүссэн нөхцлийг арилгуулах **ШААРДЛАГЫГ** танай байгууллагад хүргүүлнэ.
- Таны эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзсэн тохиолдолд **ЗӨВЛӨМЖ** гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.
- Талуудыг эвлэрүүлэх, зуучлах замаар асуудлыг шийдвэрлэх
- Ажлын байрны бэлгийн дарамт үйлдсэн албан тушаалтан, ажилтанд захиргааны шийтгэл ногдуулах тухай хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
- Шаардлагатай гэж үзвэл учирсан хохирлыг арилгуулахаар шүүхэд Таныг төлөөлөн нэхэмжлэл гаргах;
- Гомдол үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид буцаах.

**Та гомдол гаргах болон хуулийн зөвлөгөө авахыг хүсвэл
Комиссын дараах хаягаар хандаарай.**

Хаяг: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Засгийн газрын XI байр,
5 дугаар давхар
Утас: 262751, 262902
Факс: 976-11-262786
Вэб хуудас: <http://www.mn-nhrc.org>
Цахим шуудан: info@mn-nhrc.org



Таны гомдлыг хянан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг
Хувь хүний нүүцэн тухай хуулиар хадгална.



Channel
Foundation



ТА АЖЛЫН БАЙРАНДАА БЭЛГИЙН ДАРАМТАД ӨРТӨЖ БАЙНА УУ?



ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ
ХАНДАН ГОМДОЛ ГАРГААРЫЙ!!!

БЭЛГИЙН ДАРАМТ ГЭЖ ЮУ ВЭ?

Бусдыг ХҮСЭЭГҮЙ байхад нь БЭЛГИЙН СЭДЛЭЭ:

- үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн;
- эсвэл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан;
- бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэсэн;
- айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхгүй



(Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.7 дахь заалт)



АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТАД ӨРТСӨН ЭСЭХЭЭ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

Бэлгийн дарамт мөн

- Бэлгийн шинжтэй үйлдлүүд зөвхөн нэг талын хүсэл зоригоор хийгдэж байвал
- Тухайн үйлдэл нь таагүй, доромжилсон мэдрэмж төрүүлж байвал
- Бэлгийн сэдэлтэй үйлдлүүдийг санаатай, давтан үйлдэж байгаа бол
- Ажил, албан тушаал, эд материалын болон бусад байдлаар эрхшээлдээ байгааг далимдуулах болон аль нэг давуу талаа ашиглан
- Бэлгийн сэдэл бүхий саналыг хүлээн авахгүй тохиолдолд өөрт чинь ямар нэг хор уршиг, сөрөг үр дагавар учрах эрсдэлтэй байгаа бол

Бэлгийн дарамт биш

- Бэлгийн шинжтэй үйлдлүүд хоёр талын хүсэл зоригоор хийгдэж байвал
- Хүндэтгэлтэй, таатай, нөхөрсөг мэдрэмж төрүүлж байвал
- Санамсаргүй байдлаар, эмзэг газар нэг удаа хүрсэн, шүргээд өнгөрсөн бол
- Аль нэг давуу байдал, эрхшээлдээ байгааг ашигласан хандлага гаргаагүй бол
- Сэтгэлийн зовиур шаналал, айдас түгшүүргүй, хүлээн зөвшөөрөхүйц харилцаа гэж үзэж байгаа тохиолдолд

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТАД ӨРТСӨН ТОХИОЛДОЛД ТА ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

- **Эсэргүүц.**
Тухайн үйлдэл өөрт чинь таагүй, зөгүйцмээр, доромжлогдсон мэт мэдрэмж төрүүлж байгааг ойлгуул. Хүсэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ шууд хэл.
- **Баримтжуул.**
Тухайн үйлдэл үйлдэгдсэн хугацаа, байршил, хэлсэн үгс, хийгдсэн үйлдэл болон гэрчүүдийн нэрсийг тэмдэглэ. Тэмдэглэл хөтлөх, бичлэг хийх зэрэг боломжтой бүх аргаар өөрт нь мэдэгдэлгүйгээр баримтжуул.



Таны гомдлыг хинан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг
Хувь хүний нууцын тухай хуулиар хадгална.

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТАД ӨРТСӨН ТАЛААР ХЭНД ХАНДАЖ БОЛОХ ВЭ?

- Та өөрөө Хүний эрхийн үндэсний комисст (цаашид уг зөвлөмжид Комисс гэх) хандан гомдол гаргах эрхтэй.
- Хамт олондоо хандан тусламж хүс. Учир нь таньтай хамтран ажиллагч нь таны өмнөөс Хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргах эрх нь нээлттэй.
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад болон төрийн бус байгууллагад хандан зөвлөгөө ав. Эдгээр байгууллагууд таныг төлөөлөн Хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргах эрхтэй.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ ГОМДЛОО ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

- Та ажлын байрны бэлгийн дарамтанд өртсөн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсөн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.
- Гомдлыг монгол хэл дээр, бичгээр болон амаар гаргана.
- Мөн цахим хэлбэрээр гомдол гаргах боломжтой.
<http://www.mn-nhrc.org/> хаягаар орж хандаарай.
- Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд гомдлыг утсаар хүлээн авч болно.



КОМИСС ГОМДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?

1. Комисс гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хариу өгнө. Нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл хугацааг Комиссын дарга 60 хүртэл хоног сунгах болно.
2. Комиссын гишүүн таны гомдлыг хүлээн авч гомдлын мөрөөр шалгалт зохион байгуулна. Үүнд:



- гомдолд холбогдсон албан тушаалтан, бусад эрх мэдэл бүхий хүнийг дуудан ирүүлж бичгээр тайлбар, тодорхойлолт авах;
- гомдолтой холбоотой асуудлаар аль ч байгууллагад саадгүй нэвтрэх, эрх бүхий хүмүүстэй биечлэн уулзах, холбогдох материалтай танилцах;
- шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах;
- тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд шинжээч томилж дүгнэлт гаргуулах зэрэг бүрэн эрхийг эдэлдэг.

Таны гомдлыг хинан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг
Хувь хүний нууцын тухай хуулиар хадгална.



ХҮН БҮР
АЮУЛГҮЙ, ТААТАЙ,
ХҮНДЭТГЭЛТЭЙ
ОРЧИНД АЖИЛЛАХ
ЭРХТЭЙ

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТ НЬ ХҮҮЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛДЭЛ:

- ✗ Илт өвгүйцмээр бэлгийн сэдэлтэй үйлдлүүд хийх, биеийн эмзэг хэсгүүдэд хүрэх, татаж чангаах, илж таалах
- ✗ Хүсээгүй байхад тань бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх
- ✗ Хүсээгүй бэлгийн харьцаанд орохыг санал болгох, албадах, тулган шаардах, шантаажлах
- ✗ Бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах

Хэрвээ Та ажлын байрандаа дээрх үйлдлүүдтэй тулгардаг бол
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС-т
гомдол гаргаарай.

Таныг төлөөлөн танай байгууллагын ажилтан,
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ,
Төрийн бус байгууллага бас гомдол гаргаж болно.



Хүний эрхийн
үндэсний
комиссын хаяг:
Тэнгис кино
театрын өөдөөс
харсан Засгийн
газрын 11 дүгээр
байрны 509 тоот
өрөө



Цахим хаяг:
info@mn-nhrc.org



Хэрэв Та утсаар
зөвлөгөө авах бол:
Хүний эрхийн
үндэсний
комисс-262786 (Гар
утаснаас залгавал
дугаарын өмнө 51-ийг
оруулна.)
Хүчирхийллийн
эсрэг үндэсний
тов-50990505



Channel
Foundation



Ажлын байрны бэлгийн дарамт (АББД) *Монголд*



Таван эмэгтэй хүний нэг нь АББД-
д өртсөн байна. (2018)



АББД-ын арван хохирогч тутмын ес
нь эмэгтэй хүн байна. (2016)



- Үг хэлээр (33%)
- Үйлдлээр (20%)
- Бие махбодын (33%)
- Бусад хэлбэрээр (14%)

Хохирогчдын 1/3 нь үг хэлээр, 1/5
нь үйлдлээр, 1/3 нь бие махбодын
дарамтад өртжээ. (2016)



Ерөнхий боловсролын сургууль, их дээд
сургуульд АББД их илэрч байсан
бол сүүлийн жилүүдэд эрүүл мэнд,
бизнес, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг
салбарт АББД үйлдэгдэх нь нэмэгдсэн
байна. (2004, 2017)

Мөн төрийн захиргаа, төрийн үйлчилгээ,
хувийн хэвшил, албан бус хөдөлмөрийн
салбарт АББД илрэх нь нэмэгдэж байна.
(2012-2017)



Хохирогчдыг улам ноцтой, жигшм
хэлбэрээр дарамталж, хохирогчийг гэр
бүлээс нь салгасан, хүчиндсэн,
жирэмсэн болгосон байна. (2016)

Ажлын байранд бэлгийн дарамтаас
урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг
барагдуулах хэм хэмжээ, хууль
тогтоомж, эрх зүйн тогтолцоо
хохирогчийг хамгаалах, зөрчилдсөн
эрхийг нөхөн сэргээхэд хангалтгүй
хэвээр байсаар байна.

Дээрх тоо баримтыг АББД-тай холбоотой судалгаанууд болон
ХЭҮК-ын жил бүрийн УИХ-д өргөн барьдаг илтгэлээс оруулсан болно.